

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”

Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть XLVII (597)

DOI: 10.22353/ms20234701

МОНГОЛ ХЭЛНИЙ ДӨРВӨЛ БҮРЭЛДҮҮЛБЭРИЙН УТГА

Д.Бадамдорж

Түлхүүр үг: Монгол хэл, дөрвөл бүрэлдүүлбэр, бүтэц, утга

1. Удиртгал

Монголын утга зохиолын хэлний уудам орон зайд, олон зуун жилийн хэрэглээ, хувьсал, хөгжлийн явц дунд өөрөө аяндаа цэгцрэн хөгжиж, дөрөв дөрвөөрөө хэлбэр, утга ижилсэж амьсан нэгдэж, хүн төрөлхтний олон хэлнээс монгол хүний сэтгэхүйн хөгжил дэвшлээр дангааршиж ирсэн дөрвөл бүрэлдүүлбэрт бүтэц, бичил тогтолцоо буйг бид судалсан юм. Тэрхүү бичил тогтолцоо нь цуваа цагийн хувьсал, хөгжлийн явцад монгол хэл шинжлэлийн салбар, түвшин бүрд гүн бүтэц, өнгөн бүтцээрээ өвөрмөц шинжтэй болсныг ажиглав. Тухайлбал: Монгол хэлний богино эгшиг: **о, у, ө, ү** (ор, ур, өр, үр) дөрөв, урт эгшиг: **оо, уу, өө, үү** (оор, уур, өөр, үүр) дөрөв, хос эгшиг: **оё, уё, өё, үё** (ой мод, уй гашуу, өй /өртөй/, үй түмэн) дөрөв бүр нь уруулын эгшиг учраас тус тус утга ялгаж ирсэн байна гэх мэтээр авч үзлээ. Бас Халхын аялгууны хамжин шүргэх **dz, dʒ, ts, tʃ** (**з, ж, ц, ч**) гэх дөрвөл гийгүүлэгч бие биеэсээ ялгарч, утга ялгах болсон юм, Энэчлэн, жинхэнэ нэрийн **-аар /-оор, -ээр, -өөр/** гэх мэт; үйл үгийн **-лаа /-лоо, -лээ, -лөө/** гэх зэрэг дөрвөл бүрэлдүүлбэрийг хэлний нөхөх байрлалд байж, өргөлтөт үеийн тод эгшигтэй хавсарч утга ялгасан гүн бүтэц бүхий гэж дүгнэлээ. Мөнхүү зөв дуудах, зөв бичихэд, монгол хэлний дөрвөл бүрэлдүүлбэрт дэд тогтолцоо хэлэхүйн үндэслэл болно. Монгол хэл шинжлэлийн салбар, түвшин бүрд, манай хэлний хувьсал хөгжлийн явцад аяндаа цэгцрэн тогтсон **дөрвөл бүрэлдүүлбэрт** суурилсан өвөрмөц бичил тогтолцоог нарийвчлан судалж, судалгааны эргэлтэд оруулах шаардлага буй. Учир нь монгол хэлний дөрвөл нэгжээр илрэх утгыг утгалахуй, зөв дуудахуй, зөв бичихүй зэрэгт ихээхэн үүрэг, ач холбогдол бүхий юм. Дөрвөөр хэмжин хэлэлцэж буй учир бол хэлний нэгж дөрөв дөрвөөр нэгдэн ижил шинжтэй байхын хамт дөрөв дөрвөөрөө ондоошиж байгаа үзэгдэл болно.

Судалгааны ажлын зорилго: Монголын утга зохиолын хэлний бүтэц, бичил тогтолцоог гүн гүнзгий танин мэдэхийн тулд утга ба хэлбэрийн аяндаа цэгцрэн тогтсон дөрвөл бүрэлдүүлбэрийг нарийвчлан судлах, баримтаар түүнийг нотлох, судалгааны эргэлтэд оруулах.

1.1. Судалгааны ажлын зорилт: Гурван зорилтыг тавьсан: 1. Монгол хэл судлалын ямар ямар салбарт дөрвөл бүрэлдүүлбэрт бичил бүтэц, тогтолцоо байгааг тодлох. 2. Тэрхүү дөрвөл бүрэлдүүлбэрүүд ямар утгатайг тодорхойлох. 3. Зөв дуудах, зөв бичих, зохистой утгыг ялгаруулж илэрхийлэхэд дөрвөл бүрэлдүүлбэрийг түшиглэдэг учрыг тайлбарлах.

1.2. Судалгааны арга: Хэл шинжлэлийн ажиглах, товчоолох, тайлбарлах зэрэг арга хийгээд бүрэлдүүлбэрийн аргыг голлон хэрэглэв.

1.3. Судалгааны хэрэглэгдэхүүн: Монгол хэл судлаачдын туурвисан ном, өгүүлэл, нэг сэдэвт бүтээл, хэлний толь бичиг.

1.4. Судалгааны ач холбогдол: Монгол хэлний дөрвөл бүрэлдүүлбэртэй бичил бүтэц тогтолцоог судлах учир нь монгол хэлний нэгжээр илрэх утгыг утгалахуй, зөв дуудахуй, зөв бичихүй зэрэгт хэм хэмжээ баримтлах ач холбогдол бүхий юм.

2. Үндсэн хэсэг

Монголын утга зохиолын хэлний бүтэц, тогтолцооны аяндаа цэгцрэн тогтсон, нэн өвөрмөц эрэмбэлэгдсэн бичил бүтэц, тогтолцоог судалж тодорхойлох явдал бол монгол хэл шинжлэлийн судалгаа, эх хэлний сургалтад ач холбогдолтой юм. Монгол хэл шинжлэлийн түвшин, салбар бүрд дөрвөл бүрэлдүүлбэртэй, хэрэглээний явцад аяндаа цэгцэрч, бүрэлдэн тогтсон дөрвөл бүрэлдүүлбэрт бичил бүтэц, тогтолцоо бий. Монголын утга зохиолын хэл бүрэлдэн тогтох түүхэн явцад өөрөөр хэлбэл, ихэвчлэн хэлний үгийн сан-хэлзүйн хувьсал, хөгжлийн үр дүнд урт хугацаа, уудам орон зайд монгол угсаатны олон хэл аялгуунаа дөрвөл бүрэлдүүлбэр аяндаа цэгцрэх хуулиар тогтжээ. Монгол хэл хувьсан хөгжсөнийг судалж, танин мэдсэний хэрээр монгол хэл судлалд шинэ шинэ дөрвөл бүрэлдүүлбэрийг дурдсаар ч байна. Ж.Төмөрцэрэн “Монгол хэлний дагаврын зүйл эгшиг зохицохын хуулиас шалтгаалан их төлөв **дөрвөн** янзын хувилбартай болсон байдаг.” (2001:19) хэмээн хэл зүйн дөрвөл бүрэлдүүлбэрийг хэлсэн ажээ. Эдгээр дөрвөл бүрэлдүүлбэр бол хэлний хэлбэр, утгын **мэдлэг** илрэх, хэлний бүтэц, тогтолцооны доторх маш нарийн шүтэн барилдлага бүхий судлагдахуун гэдгийг бид анхлан дурдаж, онцлон тэмдэглэж байна. Монгол хэл судлалын судалгаанаас тоймлон үзвэл, дараах гол гол дөрвөл бүрэлдүүлбэр бий. Үүнд:

Нэг. Монгол хэл шинжлэлийн салбарын дөрвөл бүрэлдүүлбэр

Монгол хэл шинжлэлийн олон арван бүтээлд дурдсан, дөрөв дөрвөөрөө онцгойрон ялгарч, бичил тогтолцоо үүсгэсэн дөрвөл бүрэлдүүлбэр байдаг. Тэрхүү дөрвөл бүрэлдүүлбэрт бичил тогтолцоо нь түүхэн буюу цуваа цагийн (хэрэглээний) явцад бүрэлдсэн ажээ. Үүнд:

Авиазүй, Авиалбар зүйн дөрвөл бүрэлдүүлбэр: Монгол хэлний уруулын богино эгшиг о, и, ө, ү дөрвөлийн тухай товч авч үзье. Монгол хэлний **о, у, ө, ү** дөрвөл эгшиг бол олон монгол хэл аялгуунд сэлгэн хэлэгдэх ихээхэн өвөрмөц дөрвөл авиа юм. Ц.Дамдинсүрэн “Усыг зарим буриад аялгуунд ос гэдэг ба өндрийг халх нар өндөр гэдэг, харчинаар үндэр гэдэг, ордосын хүмүүс өндүр гэх мэтээр хэлдэг байна. Ийнхүү о, у, ө, ү хутгалдан хэлэгдэх тул о,у ба ө, ү –ийг хооронд нь ялгахгүй

адилаар бичих болжээ.” (1957:145) гэсэн байна. Эл дөрвөл бүрэлдүүлбэрийг Ш. Лувсанвандан “о, u, ö, ü dörben egesig-i keleküi-dür uruyul orulçaqu tula uruyul-un egesig kememüi” (1939:30) гэжээ. Монгол хэлний богино эгшиг: **о, u, ö, ü** (ор, ур, өр, үр) дөрөв, урт эгшиг: **ō, ū, ȫ, ǖ** (оор, уур, өөр, үүр) дөрөв, хос эгшиг: **ōē, ūē, öē, üē** (ой мод, уй гашуу, өй /өртөй/, үй түмэн) дөрөв тус тус утга ялгаж иржээ.

Х.Урьхан “Өвөг монгол хэлний үгийн эхний хоёр уруулын хамжих *Р гийгүүлэгчийн түүхэн хувьслыг “PM *parban> AM *farban> *xarban> MM harban” (2022:166) буюу **p >, f >, x >, h > 0 >** гэсэн дөрвөл гийгүүлэгчийн хувьсал болсон гэж үзжээ.

Монгол хэлний эгшиг ба гийгүүлэгч авиалбар нь ихэвчлэн **дөрвөл** бусцар авиалбар буюу хувилбартай байдаг. Ш.Лувсанвандан 1967 онд нарийвчлан тогтоожээ. Үүнд: //a// авиалбар бол: /a-ag/, /ä-äg/, /ǎ-sambär/, /ʌ-darʌlgdäl/ = **a, ä, ǎ, ʌ** ; //r// авиалбар бол: /r-arǧ/, /ř-ğerǧ/, /ṙ-ḡar/, /ṛ-ḡer/ = **r, ř, ṙ, ṛ** (1967:64, 87) гэх мэт.

Энэ мэтээр монгол хэлнээ хэт богино эгшиг **ʌ, ʌ, ʷ, ʷ** дөрвөл, кирилл монгол бичигт: **я, ё, е, ю** туслах эгшиг дөрвөл, амны гийгүүлэгч **б, п, в, ф** дөрвөл гэх мэт нэлээд олон дөрвөл бүрэлдүүлбэр утгыг ялгах болсон билээ. Утгыг ялгах гэдэг бол хэлний үзэгдлийн хувьсал хөгжлийн явцад хэлний нэгж биеэ дааж утгажна гэсэн үг юм. Жишээ нь: Хамжин шүргэх гийгүүлэгч **ts, tš, dz, dž** дөрвөл нь **Цанга-** (tsangǧ-), **чанга** (tšangǧ); **зар** (dzar), **жар** (džar) гэх мэтээр утга ялгасан байдаг. Ялангуяа, авиа зүй, авиалбар зүйн дөрвөл бүрэлдүүлбэрүүд нь үг, үглэврийн хэлбэр хийгээд утгыг ялгаж, тогтвортой болгодог ажээ.

Б.Я.Владимирцов эртний монгол бичгийн хэлэнд эгшиг үсгийн хоёр эгнээ буйг “1. гласные задние ~ гуттуральные: **a, o, u, i**

2. гласные передние ~ палатальные: **e, ö, ü, i**” (1929:118) хэмээн дөрвөл бүрэлдүүлбэртэй хос эгнээг тэмдэглэсэн байдаг юм.

Мөн Д.Төмөртоогоо “Өвөг монгол хэлний үед хэлэгдэх хүчдэлийнхээ талаар харилцан бие биетэйгээ эсрэгцэлдсэн найман богино эгшиг фонемтой байжээ.

эр (= хэлний хойгуур) / *a, *i, *o, *u /

эм (= хэлний урдуур) / *e, *i, *ö, *ü /” (1992:03) гэж богино эгшгийн чанга, хөндийн дөрвөл бүрэлдүүлбэрийг тэмдэглэжээ.

Мөнхүү Б.Х.Тодаева Орчин цагийн монгол хэлний эгшиг авиаг уруул оролцох эсэхээр нь “губные (лабиализованные) **о (oo), у (уу), ө (өө), ү (үү)**негубные (нелабиализованные) **а (aa), ы, э (ээ), и**” (1951:13) гэсэн уруулын дөрвөл эгшиг, уруулын бус дөрвөл эгшиг бий гэжээ.

Ц.Дамдинсүрэн “К, Ф, Ш, П дөрвөн үсгийг онцгой гийгүүлэгч гэж нэрлэнэ.” Мөн “Хүүхэн хэл идэвхтэй оролцож **га, го, гу, гы** гэж хэлэгдэх г үсгийг хоолойн г гэнэ. Хоолойн г-ийн ард **а, о, у, ы** дөрвөн эгшгийн нэгийг бичнэ. Жишээлбэл: арга, аргын, ботго, гудамж гэх мэт.” (1983:411) гэжээ. Орчин цагийн монгол хэлний зөв бичихзүйн зарчмыг: “1. Авиазүйн зарчим, 2. Үгзүйн зарчим, 3. Түүхэн уламжлалын зарчим, 4. Бэлгэ тэмдгийн зарчим.” (ОЦМХ, 1966:56) гэж дурджээ. Монгол хэлний нэгдүгээр үеийн бус балархай эгшгийг Б.Я.Владимирцов “1. ä, ö, ü; 2. ö, ü; 3. ё, i; 4. ь, э” (1929:311) гэсэн дөрвөл бүрэлдүүлбэртэй гэжээ.

О.Самбуудорж “... Хэлний угийн гийгүүлэгчдийн бага хос авиалбар: /X/, /G/, /k/, /g/, уруулын гийгүүлэгчдийн бага хос авиалбар: /p/, /b/, /w/, /m/, уруулын бага хос эгшиг авиалбарууд: /o/, /u/, /ö/, /ü/” (2022:129-134) хэмээн авиалбарын утга ялгаруулах байдал шинжийг ажигласан явдал тун сонирхолтой байна. Баоань хэлнээ **ā, ō, ū, ē** гэсэн урт эгшгийн дөрвөл бүрэлдүүлбэртэй ажээ (Тодаева Б. Х. 1964:05).

Үсэгзүйн дөрвөл бүрэлдүүлбэр: Сонгодог монгол бичгийн хэлнээ эр эм үсэглэвэр q, k, γ, g Н,k,G, k хэмээх дөрвөл бүрэлдүүлбэр гэх мэт бий. Ш.Лувсанвандан: “Хуучин монгол хэлзүйчин нарын хатуу дэвсгэр: b, γ, g, r, s, d, зөөлөн дэвсгэр: **m, n, ŋ, l** гэж байсан нь b, γ, g, r, s, d нь үгийн эцэст мөн s гийгүүлэгчийн нэгэн адил цөм дуугүй болдог, **m, n, ŋ, l** нь ямагт дуутай хэвээрээ байдаг учир тэгж ялгасан байна.” (1967:54) гэж үндэсний бичгийн зөөлөн дэвсгэр үсэг дөрвөлийг ажигласан байна.

Ж.Надмид “Хуа-и и-юй бол 14-р зууны үеийн монгол хэлний онцлог шинжүүдийг хадгалсан чухал дурсгалын нэг болно. ... Хятад бичигт o, ö, u, ü ялган тэмдэглэхэд бэрхтэй учраас монгол хэлний **4 авиаг** ихээхэн хутгаж бичсэн байна. Бас эр үгний q, γ, эм үгний k, g хоёрыг төдий л ялгасангүй” (1967:74) гэсэн явдал монгол хэлний дөрвөл авиа, авиалбарын онцлогийг хэлсэн ажээ. Ер үсэгзүй /авиазүй/-д үндэсний бичиг, кирилл бичиг зэрэгт хос хийгээд дөрвөл бүрэлдүүлбэрээр хэлэлцэх b/ v; γ/g; c/ č; j/ j гэх мэт гийгүүлэгч үсэг ч бий. Кирилл шинэ бичигт хоолойн **г**, хэлний **г**; хэлний үзүүрийн **н**, хэлний угийн **н** хэмээсэн хос дөрвөл авиа, үсэг бол зөв дуудах, зөв бичих, үгийн утга ялгахад машид өвөрмөц онцлогтой байдаг ажээ. Орчин цагийн монгол хэлнээ дөрвөн гийгүүлэгч дараалан орох шинэвтэрхэн дөрвөл бүрэлдүүлбэр буй болсон билээ. Жишээ нь: **эмхтгэх**, **цомхтго**-, **төрөлхтний**, **эрхтний** гэх мэт. Б.Ринчен: “...Кирил үсгийн зарим үсэглэвэр нь тухайлбал, **я, ё, е, ю** энэ дөрвөн, хэлний магнайн шүргэх гийгүүлэгч + эгшиг хоёроор бүтсэн үеийг нэгэн үсэглэврээр тэмдэглэсэн тул, авианы үсгийн цагаан толгойд дөрвөн үсэг нь үет үсэг байгаа хэрэг.” (1966:316) хэмээн авиазүйн нэгэн чухал дөрвөл бүрэлдүүлбэрийг хэлжээ. Кирилл бичигт **й, ь, ы ь** үсгүүд том үсэггүй дөрвөл бүрэлдүүлбэр юм. Монгол хэлний **о, у, ө, ү** дөрвөл эгшиг үсэг бол олон монгол хэл аялгуунд сэлгэн хэлэгдэх ихээхэн өвөрмөц дөрвөл авиа үсэг юм. Авиазүйд ч үсэгзүйд ч хамааруулж хоёр талаас нь хэлэлцэж болох авиа үсэг бий. Жишээ нь:

Ц.Дамдинсүрэн “**К, Ф, Щ, П** дөрвөн үсгийг онцгой гийгүүлэгч гэж нэрлэнэ. Мөн “Хүүхэн хэл идэвхтэй оролцож **га, го, гу, гы** гэж хэлэгдэх г үсгийг хоолойн г гэнэ. Хоолойн г-ийн ард **а, о, у, ы** дөрвөн эгшгийн нэгийг бичнэ. Жишээлбэл: арга, аргын, ботго, гудамж гэх мэт” (1983:411) гэжээ.

Ц.Дамдинсүрэн “**Ж, З, Ц, Ч** дөрвөн үсгийг ялгасан явдал бол орос, хятад зэргийн гадаад хэлний үг, хүний нэр зэргийг зөвөөр тэмдэглэн бичихэд их тусыг хүргэнэ” (1957:152) гэсэн байдаг. Монгол хэлний авиа ба үсэгт: Үсгийг **үзэх, бичих**, авиаг **хэлэх, сонсох** хэмээсэн хүмүүн үйлдэхүйн дөрвөн бүрэлдүүлбэр байдаг ажээ.

Хэлбэр судлал, бүтээвэр зүйн дөрвөл бүрэлдүүлбэр: Монгол хэлний хувьсал, хөгжлийн тоо ба чанар илтгэх, нийт монгол хүмүүний хэрэглээнд монгол хэл, хэлэхүйн зарим үзэгдэл нь дөрвөл бүрэлдүүлбэр бүхий тогтоц ч бий. Ш.Лувсанвандан “Тогтворгүй н-ээр төгссөн үгс нь н-тэй, н-гүй хоёр янзын үндэстэй, бусад үгс нь хоёроос **дөрөв** хүртэл үндэстэй байдаг. ... Нэгдүгээр ганц биеийг заах би гэсэн үг нь **би-, мин-, нам-, над-** гэсэн дөрвөн үндэстэй ...” (1968:163) гэж тайлбарласан ажээ. М.Базаррагчаа “Монгол хэлний үе-утгалбар (силла-семема) -ууд нь *pa... ~ qa... ~ śa... ~ ta...* (товчоор “**paqasata**” буюу “**patasaqa**” гэж болно.) гэсэн **дөрвөл** үндсэн үе-утгалбараас үүсэлтэй бөгөөд үүний эхний хоёр нь “хурах бөөгнөрөх” буюу “бүтэх”, сүүлчийн хоёр нь “салах сарних” буюу “эвдрэх” утгатай юм. Гэвч харьцангуйн үүднээс, “бүтэх” нь “эвдрэх” утгыг, “эвдрэх” утга нь “бүтэх” утгыг агуулдаг” (2005:244) хэмээн эртний монгол хэлний үе-утгалбарын дөрвөл бүрэлдүүлбэрийг судалж тогтоосон байна. Мөн Б.Напил “... Алтай өвөг хэлний анхдагч махбод нь ердөө л “**Р, Т, Ѕ, К**” авиалбар л болж байгаа билээ.” (2021:102) хэмээн бичсэн явдал холбогдож ирж байна.

А, е, о, ө дөрвөн эгшигт суурилсан дагавар ба нөхцөл бүтээврийн доторх **-на/-** нэ, **-но**, **нө/** цаг заах нөхцөл, 1. **-уул/-үүл/**, 2. **-лга/-лгэ**, **-лго**, **-лгө/**, 3. **-га/-гэ**, **-го**, **-гө/**, 4. **-аа/-ээ**, **-оо**, **-өө/** үйл үгийн үйлдүүлэх хэв гэх мэт дөрвөл бүрэлдүүлбэр, өгүүлбэрийн шууд биш тусагдахуун нь жинхэнэ нэрийн өгөх орших, гарах, үйлдэх, хамтрах дөрвөн тийн ялгалаар хэлбэржих дөрвөл бүрэлдүүлбэр гэх мэтийг дурдаад, заримыг нь дэлгэрүүлэн авч үзье.

Б.Х.Тодаева “...Үйлдэгдэх хэв /страдательный залог/, үйлдэлцэх хэв /совместный залог/, үйлдэлдэх хэв /взаимный залог/, үйлдүүлэх хэв /побудительный залог/ ...” (1951:124-127) гэсэн **дөрвөл** бүрэлдүүлбэртэй гэж үзжээ.


Үйл үгийн өмнө байрлаж, үгүйсгэх захирах (отрицания и запрета...), хориглох утга заадаг “**үл, эс, битгий, бүү**” (Санжеев, Г.Д. 1960:79) гэх **дөрвөл** бүрэлдүүлбэр бол хэлзүйн үгийн нөхцөлийн дайтай бөгөөд нугархай хэлний утгвар үгийг санагдуулсан нэн өвөрмөц хэлбэр утгатай юм. Жишээ нь: “...бичиг **үл** мэдэгч, **үл** ялих шалтгаан, **үл** бүтэх этгээд, Энд тамхи татаж **үл** болно., түүнийг **үл** мэднэ, **эс** мэдэгч, **эс** мэдэв, чи **эс** мэджээ, Та **бүү** зовогтун., Та **битгий** сандрагтун., **бүү** мэд, **бүү** үзэгд, **бүү** сана, ...гэх мэт.” (ОЦМХ. 1966:230-231) Мөн хэл судлаачид монгол үгийн **үеийн** бүрэлдүүлбэрийг товчоолсон ч байдаг.Б.Ринчен:

“1. Ганц эгшгээр бүтсэн үе нь, ...Нэгд. Дан ганц ерийн эгшиг байж болно. Хоёрт. Ганц урт эгшиг байж болно. Ганц хос эгшиг байж болно. Энэ гурван зүйл үе цөм ганц эгшгээр бүтсэн үе бөгөөд, гагцхүү үгийн эхэнд байдаг үе болно./а-ми, а-рал, аа-жим, ай-маг/,

2. Эгшиг гийгүүлэгч хоёроор бүтсэн үе байж болно. ... Гагцхүү үгийн эхэнд байхаас, үгийн дунд адагт огт байдаггүй зүй тогтолтой./эр-дэм, ог-цом/,


3. Гийгүүлэгч эгшиг хоёроор бүтсэн үе байж болно./но-хой, мо-гой, дуу, дүү, за-луу/,

4. Гийгүүлэгч эгшиг гийгүүлэгч гурваар бүтсэн үе байж болно. /гал, ну-таг, цээл/.” (1966:398-399) гэжээ. Мөн Ш.Лувсанвандан Монгол хэлний үгийн үе нь дөрвөл бүрэлдүүлбэртэй байна(1939:40) гэжээ. Үүнд:



Бүдүүвч № 1. Үгийн үе: Задгай үе, битүү үе.

Д.Төмөртоогоо: “Монгол хэлний үеийн үндсэн бүтэц нь бүр эртний монгол хэлний үеэс эхлээд өдгөө хүртэл доор дурдсан **дөрвөн** янзын бүтэцтэй байжээ.




Бүдүүвч № 2. Үгийн дөрвөл бүрэлдүүлбэрт үе

Монгол бичгийн хэлний үндэсний бичгээр бичсэн, зүрхэн толтоос өнөө хүртэлх хэлзүйн бичгүүдэд эр эгшиг орсон үгийг эр үг, эм эгшиг орсон үгийг эм үг гэсэн үндэслэлээр зарим үг бүтээх дагавар, хэлзүйн олон айн нөхцөл гэх зэрэг нь хэрэв үгийн хүчдэлтэй эгшиг бүхий үед а, о, у, *i эгшиг байрласан бол эр эгшигт залгавар, хэрэв үгийн хүчдэлтэй эгшиг бүхий үед э, ө, ү, *i эгшиг байрласан бол эм эгшигт залгавар залгадаг хос бүрэлдүүлбэртэй, зэрэгцээ бүтэцтэй тогтолцоо байдаг. Өөрөөр хэлбэл, үндэсний бичгээрх ихэнх дагавар ба нөхцөл бүтээвэр нь хоёр хувилбартай байдаг. Орчин цагийн монгол хэлнээ тэдгээр нь дөрвөл бүрэлдүүлбэртэй болсон ажээ. Жишээлбэл: Монгол хэлний цагт нэрийн -day, -deg (-даг, -дэг, -дог, -дөг) нөхцөл нь:

Эртний бичгийн хэл

Орчин цагийн бичгийн хэл



Бүдүүвч №3. Бүтээврийн дөрвөл хувилбар=бүрэлдүүлбэр

Монгол хэлний бүтээврийн энэ тогтолцооны бүрэлдүүлбэрүүд бол үгийн хүчлэг өргөлтөө дагасан эгшиг зохицох ёсоор байрлах бөгөөд хүчлэг өргөлтийн тодэгшиг, хүчлэг бус өргөлтийн балархай эгшиг хоёр нь бие биеэ тэнхрүүлж, үгийн утга ялгаруулдаг ажээ. Жишээ нь: Hereeedede(qaraydadaγ ‘харагддаг’ qarāgdādag гэх үгийн хэлбэрт орсон хүчлэг өргөлтөт эхний [a] авиалбараа дагаж, дараагийн үеүдэд байрласан балархай ă, ǎ, ȧ тус бүр нь утга ялгаруулахад оролцоно гэсэн саналтай байна. Эгшиг зохицохын учир утга нь энэ юм. Бүтээвэрзүйн үүднээс үглэвэрт байгаа дөрвөл бүрэлдүүлбэрийг ажиглавал, язгуур бүтээвэр, дагавар бүтээвэр, нөхцөл бүтээвэрт нэгэн адил тохиолдож байна. Монгол бичгийн хэлнээ зөв бичих, зөв дуудах учир шалтгаанаар үсгийн дүрмийн ёсоор t, d, j, j, ɕ, c гэх зэрэг гийгүүлэгчтэй холбоотой авиазүй, үсэгзүйн, бүтээвэрзүйн учир холбогдолтой дөрвөл бүрэлдүүлбэр хэд хэд буй болжээ. Жишээ нь: Судлаачид: “-tur, tayan, -dur, -dayan; -tür, -tegen, -dür, -degen” хос дөрвөл бүрэлдүүлбэрийн бичих ёсыг үзүүлсэн ч байдаг. Хэлний бүтээвэр бол утгажсан бүрэн бус дохио юм. Тэрхүү дохионы дөрвөл бүрэлдүүлбэрийг нарийвчлан онцолж авч үзье.

Язгуур бүтээврийн дөрвөл бүрэлдүүлбэр: Язгуур бүтээвэр нь нөхөх байрлалд байх дөрвөл хувилбартай нь цөөвтөр боловч, нэлээд үглэвэрт тохиолдож байна. Ш. Лувсанвандан: “Монгол хэлний дэ- идэвхгүй язгуур нь дэ-, дэг-, -дий, -дэн гэсэн хэдэн хувилбараар илэрнэ.

- а. **дэ-:** дэ+в > дэв –/өндөр дэв дээр гэрээ барих/, дэ+л > дэл –/морины дэл, дэл хад/, дэ+в > дэв- /гараа дэвэх/, дэ+л > дэл- /гараа дэлэх/ гэх мэт.
- б. **дэг-:** дэг+ж > дэгж- /хөгжих/, дэг+д > дэгд- /харайх/ гэх мэт.
- в. **дий-:** дий+л > дийл-/ялах/ гэх мэт.
- г. **дэн-:** дэн+д > дэнд-/хэтрэх/, дэн+ж > дэнж/газар/, дэн-хэр > дэнхэр/том/ гэх мэт.” (1968:105)

Монгол хэлний тэ-язгуур нь тэ-, тү-, ти-, тө- гэсэн хувилбартай.

- а. **тэ-:** тэ+р > тэр, тэ+д > тэд,
- б. **тү-:** тү+үү > түү-, түүн-,
- в. **ти-:** ти+ий > тий, тийш, тийм,
- г. **тө-:** тө+дий > төдий гэх мэт.” (1968:108) язгуурын дөрвөл хувилбарыг дурджээ.

Монгол хэлний зарим үгийн идэвхгүй язгуурын хувилбар **дөрвөл** байгаа нь аяндаа цэгцрэн тогтсон бүрэлдүүлбэр юм. Мөнхүү монгол хэлний нэгдүгээр биеийн ганц тоот төлөөний би гэсэн үг нь дөрвөл бүрэлдүүлбэрийн нэгэн жишээ болно. Үүнд:

- би-**(нэрлэхийн тийн ялгал/би-//o//),
- мин-**(харьяалахын тийн ялгал/мин-ий/),
- над-**(өгөх орших /над-ад/, үйлдэх/над-аар/, хамтрах/над-тай/, чиглэх/над-руу/ гэх мэт тийн ялгал),
- нам-**(заахын тийн ялгал/нам-айг) гэсэн дөрвөн өөр үндэс-бүрэлдүүлбэртэй (Лувсанвандан, Ш. 1968:163) байдаг.

Монгол хэлний язгуур бүтээврийн **о, у, ө, ү** гэсэн дөрвөл бүрэлдүүлбэрт уруулын богино эгшиг авиалбарзүйн утга ялгаруулах үүрэгтэйг хэл шинжээчид тэмдэглэсэн байна. С.Галсан: “...хол(далеко), хөл(нога), хул(масть лошади-саврасый), хүл-(завязывай) (1975:30) гэжээ. Мөн монгол хэлний дөрвөл богино, урт уруулын эгшиг өөр хоорондоо эсрэгцэж, утга ялгаруулж байгааг Д.Бадамдорж: “...сор/үсний сор/, сур-/ном сур-/, сөр-/урсгалыг сөр-/, сүр/сүр бараа/, ноо-/оноох, ноох идэвхгүй/, нуу-/нуух хаах/, нөө-/хүчээ нөөх/, нүү-/нүүх суух/ гэх мэт” (2001:17) гэж тэмдэглэжээ. Энэ нь В.М.Солнцев: “Орос хэлний дам, дом, дим, дум бүтээврийн утгыг а, о, и, у авиалбараар ялгаруулж байна.” (1983:65) гэсэнтэй дүйж буй нь хэл хэлнээ ийм өвөрмөц дөрвөл эгшиг байдаг бололтой.


Орчин цагийн монгол хэлний үгийн язгуурын бүрэлдүүлбэрийг нь монгол хэл шинжлэлийн бүтээлд: “**Язгуур нь** хэл хэлэнд янз янзын авиа зүйн онцлогтой байдаг. Жишээлбэл: Монгол язгуур нь хэлний хойгуур өгүүлэгдэх н, мөн р авиа, хоёр гийгүүлэгчээр эхэлдэггүй, гол төлөв ганц үеэр бүтдэг. Чингэхдээ дан эгшиг, эгшиг гийгүүлэгч, гийгүүлэгч эгшиг, гийгүүлэгч эгшиг гийгүүлэгч гэсэн ийм **дөрвөн** янз үеэр бүтдэг. Үүнд, эгшгийг Э, гийгүүлэгчийг Г гэж хураангуйлбал доорх томъёолол хийж болно. Жишээ:

Э оо, өө, ий, а-хуй,
ЭГ он, үүр(цайх), ав, өс-вөр,
ГЭ та, гэ-, хий-, я-с(йа-с)

ГЭГ гар, гал, хэв, бол-гоомж.” (ОЦМХ. 1966:68) гэж дурдсан байна.

Дагавар бүтээврийн дөрвөл бүрэлдүүлбэр: Хэрэв үгийн дагавар бүтээврийн бүрэлдүүлбэрт богино эгшиг орвол их төлөв дөрвөл хувилбар (бүрэлдүүлбэр)-тай байх бөгөөд **дөрвөл хувилбар нь** хүчдэл бүхий эгшиг балархай эгшиг хоёр зохицон хамжин хавсарч, утгыг ялгаруулаад, ингээд хэлний нөхөх байрлалын ёсоор бие биеэ нөхөж, нэгэн утгыг илэрхийлнэ. Балархай эгшиг утгыг хамжин хавсарч ялгаруулна гэсэн үг. Жишээлбэл: Үйл үгийн үндсэнд –мал/ -мэл, -мол, -мөл/ дагавар залгаж, тухайн үйлийн үр дүнгийн шинжийг заасан тэмдэг нэр үүсгэх бөгөөд эгшиг зохицох ёсоор дөрвөл балархай эгшиг(а, э, о, ө) утгыг хамжин хавсарч ялгаруулдаг. Үүнд:

1. Барь+мал=баримал,
2. нэх+мэл=нэхмэл,
3. ор+мол=ормол,
4. гөр+мөл=гөрмөл



- a. –мал **а** хувилбар
- b. –мэл **э** хувилбар
- c. –мол **о** хувилбар
- d. –мөл **ө** хувилбар гэх мэт.


Бүдүүвч № 4. Дагавар бүтээврийн дөрвөл бүрэлдүүлбэр

Эдгээр нь дахин тодруулан хэлбэл, үгийн өргөлтөт эгшгээ дагаж, дараа үе дэх авиалбарын хувилбар: **ᠶ, ᠡ, ᠦ, ᠣ /а, э, о, ө/** бүрэлдүүлбэр нь утгыг хамжин хавсарч ялгаж байгаа тогтоц юм. Хэрэв баримэл, нэхмэл, ормөл, гөрмөл гэж байрлуулбал монгол үг гэдэг нь танигдахгүй болно. Мөн үгэнд эгшиг жийрэглэвэл, дөрвөл

балархай эгшиг ч бичнэ. Жишээ нь: Таар-**а**-мж, сэр-**э**-мж, тохир-**о**-мж, төхөөр-**ө**-мж гэх мэт. Эл дөрвөл балархай эгшиг бол эгшиг зохицох ёсоор өргөлтөт эгшигтэй хэлбэр утга шүтэлцэж, утгыг хамжин хавсарч ялгана.

Хэлний дөрвөл бүрэлдүүлбэртэй дагавар бүтээвэр бол үгийн санг улмаар баяжуулах нөөц хөрөнгө, хүчин зүйл болдог ажээ. Дагавар бүтээврийн нэгэн хувилбар нэг үг бүтээнэ. Жишээлэхэд, -дал/-дэл, -дол, -дөл/ дагавар бүтээврийн дөрвөн бүрэлдүүлбэр нь үйл үгээс жинхэнэ нэр үүсгэхдээ үгийн сангийн **дөрвийн дөрвөн** үглэвэр бүтээдэг ажээ. Чойжинжав: “Эгшиг зохицсон хэдэн **хэлбэр**: ... -bar, -ber, -bor, -bör: салбар, үлдвэр, ноогдвор, нөхвөр гэх мэт.” (1989:280-281) гэж тэмдэглэжээ. Энэ утгаар үгийн сан нь дагавар бүтээврийн дөрвөл бүрэлдүүлбэрээр баяжиж иржээ. Загварчилбал:

Дөрвөн үг бүтээсэн гэж болно.



Бүдүүвч № 5. Дагавар бүтээврийн дөрвөл бүрэлдүүлбэр

Ялангуяа, “үнийн хөөргөдөл” гэх мэтээр шинэ нэр томьёо нэлээд бүтээж байна. Үгийн сан баяжсаар л байна. Эл дөрвөл бүрэлдүүлбэрт дагавар бол хэлний дангааршсан, үгийн сан-хэл зүйн бүтэц, дэд тогтолцоо мөн юм.

Нэр үг бүтээх дөрвөл бүрэлдүүлбэр: Монгол хэлний дөрвөл хувилбар=бүрэлдүүлбэртэй дагавар нь дөрвөн өөр үглэвэр бүтээдэг ажээ. Жишээ нь:

-дал (-дэл, -дол, дөл) буудал, нүүдэл, оргодол, өргөдөл,
 -лаг (-лэг, -лог, -лөг) чулуулаг, эвэрлэг, ойлог, төмөрлөг,
 -тан (-тэн, -тон, -төн) араатан, жигүүртэн, ноёнтон, хөхтөн,
 -мэд (-мэд, -мод, -мөд) ахмад, дүүмэд, зочмод, өцүүхмөд,
 -гана (-гэнэ, -гоно, -гөнө) улаалзгана, гүзээлзгэнэ, боролзгоно, бөөрөлзгөнө,
 гэх мэт.

Үйл үг бүтээх дагаврын дөрвөл бүрэлдүүлбэр:

Мөн янз бүрийн үндсээс шинэ үг бүтээх дөрвөл бүрэлдүүлбэртэй дагавар бол дөрвөн өөр үг бүтээнэ.

- -ла (-лэ, -ло, -лө) малла-, дэтэрлэ-, номло-, өвлө-,
- -шаа (-шээ, -шоо, -шөө) сайшаа-, тээршээ-, ойшоо-, төвөгшөө-,
- -аа (-ээ, -оо, -өө) хатаа-, элээ-, оноо-, сөнөө- гэх мэт.

Ц.Өнөрбаян “Гадаад байдал дүрслэх чөлөөт биш язгуураас үйл үг бүтээх -ай-, -схий-, -гана-, -лз- **дөрвөн** дагавар үйл хөдлөлийн ганц, олон удаа, удаан, хоромхон, эрчимтэй болох зэрэг болцын ялгамжийг ялган заах үл тусах үйл үг бүтээнэ. Үүнийг дараах жишээнээс ажиглаж болно. Сартай-, сартасхий-, сарталз-, сартгана-, гэдий-, гэдэсхий-, гэдэлз-, гэдгэнэ-, хотой-, хотосхий-, хотолз-, хотгоно- гэх мэт” (2000:100) хэмээх нэн өвөрмөц бүрэлдүүлбэр байгааг дурдсан байна.

Нөхцөл бүтээврийн дөрвөл бүрэлдүүлбэр: Данзандагва: “...Үгсээр утгыг үзүүлэх бөлгөө. Утгыг үзүүлэх тэр цаг-тур нөхцөл хэрэгтэй болай.” (МХШДБ. 1983:11) гэж үг нөхцөл хоёрын шүтэлцээг хэлжээ. Монгол сонгодог бичгийн хэлнээ үндэсний бичгийн үсгийн дүрмийн ёсоор дөрвөл бүрэлдүүлбэр бүхий зарим нөхцөл бүтээврийн хувилбар бий бөгөөд хэлзүйн дөрвөл үг, хэлбэр бүтээсэн байдаг ажээ. Жишээлбэл: Нэр үгийн тийн ялгалын зарим нөхцөл нь дөрвөл бүрэлдүүлбэртэй байдаг. Өгөх оршихын тийн ялгал: **-dur, -dür, -tur, -tür:** aq-a-dur, eke-dür, aqas-tur, ekes-tür; Үйлдэхийн тийн ялгал: **-bar, -ber, -iyar, -iyer:** aq-a-bar, eke-ber, aqas-iyar, ekes-iyer (Лувсанвандан. 1939:62-63); Зүрхний толт, зүрхний толтын тайлбар гэх мэт хэлзүйн бичиг бүтээсэн Гунгаажалцан, Пагва лам Лодойжалцан, Чойжи-Одсэр, Гунгаа-Одсэр, Данзандагва, Агваандандар нарын зэрэг хэл зүйчид “... Debisger ügei-dür **-bar, -ber, kiged debisger-tei-dür – iyar, -iyer bičikü bolai.**” (Пагва. 1957:30) гэх мэт дөрвөл бичил бүтэц, тогтолцооны хуулийг баримталж иржээ.

Үйл үгийн тийн ялгалын зарим нөхцөл нь дөрвөл бүрэлдүүлбэртэй байдаг. Үйл үгийн зэрэгцэхийн тийн ялгал: **-ju, -jü, -ču, -čü** (orju, irejü, odču, ögčü) үйл үгийн өнгөрсөн цагийн дөрвөл нөхцөл: **-juqui, -jüküi, -čuqui, -čüküi** (yabujuqui, irejüküi, үгčüqui, ögčüküi) гэх мэт. Энэ мэт хэлзүйн үгийн нөхцөлийн хүрээнд байгаа дөрвөл бүрэлдүүлбэртэй хэдэн нөхцөл бол хэлзүйн үгийн утгыг ялгах, зөв бичих, зөв дуудах үндэслэл болдог ажээ. Ялангуяа, хэлзүйн эр үг, эм үг хэмээх хэлний мэдлэгийг илтгэж, хэл зүйн нэгэн утгыг илэрхийлэх өвөрмөц дөрвөл бүрэлдүүлбэр болно.

Орчин цагийн монгол хэлний нөхцөл бүтээврийн хүрээнд дөрвөл бүрэлдүүлбэр хамгийн олон тоотой бөгөөд нөхцөлийн хувилбар нь хэлэхүйд машид өргөн хэрэглээтэй байх онцлогтой ажээ. Монгол хэлний зөв дуудахзүйн хамаарал их байдаг байна. Жишээлбэл: Нэгдүгээр биед хамаатуулах -я, -ё, -е/э/, -е/ө/ дөрвөн нөхцөлийг өгүүлбэр төгсгөн хэлэхдээ зарим халх хүн эгшиг зохицох ёсыг эс баримталж хэлж байх юм. Ялангуяа, -ё, -еэ, еө гэх гурван хувилбарыг а-гаар хэлдэг болчихсон. ... сайн сайхныг хүсье, ... өргөн дэвшүүлье, ... хүсэн ерөөе гэх зэргийг ... хүсьяа, дэвшүүльяа, ерөөяа гэж буруу дуудах хүн байх юм. Мөн цагт нэрийн өнгөрсөн цагийн нөхцөлийн -сан/ -сэн, -сон, -сөн/ дөрвөн хувилбарыг орчин цагийн төв халхын аялгуунд –цан, -цэн, -цон, -цөн гэж дуудаж байгаа. Телевиз, радио, гэр бүлийн нөхцөлд энгийн ярианд явцан, ирцэн, орцон, өгцөн гэсэн хувилбартай болсон байна.

Нэр ба үйл үгийн нөхцөл бүтээврийн дөрвөл хувилбар/бүрэлдүүлбэр/-ын тухай нарийвчлан авч үзье. Хэлзүйн үгийг бүтээсэн нөхцөлийн нэг хувилбар-бүрэлдүүлбэр бол хэлзүйн нэг үг бүтээнэ. Монгол хэлний үйл үгийн тийн ялгалын үргэлжлэхийн –саар/-сээр, -соор, -сөөр/ дөрвөн хувилбар хэлзүйн дөрвөн үг/явсаар, ирсээр, олсоор, өгсөөр/ бүтээж чадна гэж бид үзлээ.

Жинхэнэ нэрийн дөрвөл нөхцөл: Я.Шмидт монгол хэлний өгөх оршихын тийн ялгалын “**-tayan, -dayan, -tegen, degen**” (1832:25) дөрвөлийг зөв бичих үүднээс тайлбарласан ажээ. А.Бобровников үйл үгийн үйлдэхийн тийн ялгалын “**-bar, -ber, -iyar, -iyer**” (1849:97) дөрвөлийг тэмдэглэжээ.

Жинхэнэ нэрийн тийн ялгалаас **гарах, үйлдэх, хамтрах, чиглэх** дөрвөн тийн ялгалын нөхцөл дөрвөл бүрэлдүүлбэртэй байна. Монгол хэвшмэл хэлцийг Монголын ард түмэн бүтээж, үеийн үед монгол хүний нэг тархинаас нөгөө тархинд уламжлан хадгалж ирсэн нь гарцаагүй. Тэгэхдээ тухайн нэг жишиг загвараар тархиндаа хадгалдаг байна. Тийм жишиг загварын нэг бол харьцуулах сэтгэмжийн загвар юм. Энэ нь нэгэн үйл явдлаас нөгөө үйл явдал нь зөв, чанартай, үр дүнтэй, хэрэгтэй болохыг сургасан утга санаатай цөөнгүй хэвшмэл хэлц байна. Тийм загварыг авч үзье. Жинхэнэ нэрийн гарахын тийн ялгалын нөхцөл нь:

Загвар нь: А: нэр + -аас, Б: ... дээр


А: барсаас, Б: шаазгай дээр

Жишээ нь: -аас: Цувж явсан барсаас,

Цуглаж суусан шаазгай дээр.

-оос: Сүүлгүй чононоос,

Сүүлтэй чоно дээр.



Бүдүүвч № 6. Нөхцөл бүтээврийн дөрвөл бүрэлдүүлбэр

-ээс: Сэтгэлийн хирээс,

Нүүрийн хир дээр.


-өөс: Сээрийн бөхөөс,

Сэтгэлийн бөх дээр гэх мэт.

Эл дөрвөн хувилбар нь хэлний нөхөх байрлалд байж, зөвхөн хэлбэр, байраар бие биеэсээ ялгарч, утга үл ялгана. Жинхэнэ нэрийн үйлдэхийн тийн ялгалын нөхцөл нь:

(...ЦАГТ НЭР + аар, ...ҮЙЛ ҮГ) хэмээх хэвшмэл хэлцийн зохиомж, сэтгэмжийн **загвараар** 90 орчим хэвшмэл хэлцийг бүтээсэн байх жишээтэй байна. Жишээ нь:

1. Нэр хугараха**ар**, Яс хугар.
2. Эдээр биеэ чимэх**ээр**, Эрдмээр биеэ чим.
3. Амьд хүний гэрч болохо**ор**, Үхсэн хүний дэр бол.
4. Тэнэг хүнд ерөөлгөх**оор**, Цэцэн хүнд хараалга гэх мэт.



Бүдүүвч №7. Нөхцөл бүтээврийн дөрвөл бүрэлдүүлбэр

Жинхэнэ нэрийн тийн ялгалаас **хамтрах** тийн ялгалын нөхцөл ч дөрвөл бүрэлдүүлбэртэй байна. Жишээлэхэд, хамтрахын тийн ялгалын -tai, -tei, -luγ-a, -lüge нөхцөлийн дөрвөл бүрэлдүүлбэр бол ижил утганцарт (омосемия) юм.

Монгол хэлний хэлзүйн үгийн нөхцөл бүтээврийн бүрэлдүүлбэрт а, э, о, ө дөрвөл богино эгшиг бие биеэ нөхөж, өвөрмөц бүтэц үүсгэдэг байна. Цагт нэрийн өнгөрсөн цагийн –сан/-сэн, -сон, -сөн/, одоо цагийн –даг/ -дэг, -дог, -дөг/, одоо ирээдүй цагийн –аа/ -ээ, -оо, -өө/ гэх мэт дөрвөл бүрэлдүүлбэр бий. Эдгээр нь өргөлтөт үеийн хүчлэг эгшигтэй хавсарч, цагийн утгыг ялгаруулж, мөн зөв дуудах, зөв бичихэд суурь мэдлэг болно.

Үйл үгийн дөрвөл нөхцөл

Монгол хэлний үйл үгийн үйлдүүлэх хэвийн нөхцөл нь: 1. -уул (-үүл); 2. -лга (-лгэ, -лго, -лгө); 3. -га (-гэ, -го, -гө); 4. -аа (-ээ, -оо, -өө) гэсэн үйл үгийн үндсийн хойно байрлах байраараа илт ялгарч, зөв дуудах, зөв бичихийн үндэс болж, хэлзүйн хийсвэр, бусдаар үйлдүүлэх утга ялгах **дөрвөл** бүрэлдүүлбэртэй байна.

Үйл үгийн тийн ялгалын дотроос урьдчилах: -аад/-ээд, -оод, -өөд/, болзох: -бал/-бэл, -бол, -бөл/, -вал/ -вэл, -вол, -вөл/, угтах: -тал/-тэл, -тол, төл/, бэлтгэх: -магц/-мэгц, -могц, -мөгц/, зорих: -хаа/-хээ, -хоо, -хөө/, дагалдах: -хлаар/-хлээр, -хлоор, -хлөөр/, далимдах: -нгаа/-нгээ, -нгоо, -нгөө/, үргэлжлэх: -саар/-сээр, -соор, -сөөр/, магадлах: -мааж/-мээж, -моож, -мөөж/ гэх мэт. Эдгээр дөрвөл дөрвөл хувилбар бол хүчлэг өргөлтөт үеийн эгшиг авиалбараа дагаж, өргөлтөт бус үеийн балархай богино эгшиг зөвхөн хэлзүйн үгийн утгыг хавсарч ялгаруулах үүрэгтэй байна. Мөн зөв дуудах, зөв бичихийн үндэс болохыг Ж. Санжаа нар: “Монгол хэлний **балархай эгшиг** нь зөв бичих дүрэм боловсруулах, зөв дуудах зүйг тогтооход чухал учир холбогдолтой” (2008:117) гэж үзжээ.

Үйл үгийн болзохын тийн ялгалын -бал/-бэл, -бол, -бөл/, -вал/ -вэл, -вол, -вөл/ **хос** дөрвөл хувилбар гэхэд л хэлбэр, байраараа эсрэгцэж, бие биеэ нөхөж, утга үл ялган, гагцхүү өргөлтөт үеийн эгшгийн дагуу зохицож, утгыг хамжин хавсарч ялгаруулах үүрэгтэй байх дөрвөл бүрэлдүүлбэр юм. Эл дөрвөл балархай **а, э, о, ө** /а, э, о, ө/ эгшгээр бүтсэн бүрэлдүүлбэр бол үгийг **зөв дуудах, зөв бичихэд** нотолгоо болдог ажээ. Жишээ нь:

Ал**бал** ахадна,


Алгад**вал** багадна.

Тоол**бол** нас чацуу,

Төөл**бөл** нуруу чацуу.

Айраг бүл**бэл** тос унадаг,

Авир сөр**вөл** цус унадаг.



a. -бал,

b. -бэл,

c. -бол,


d. -бөл.

Ай**вал** бүү хий,

Хий**вэл** бүү ай.

Алттай ойрт**вол** шарлана,

Хөөтөй ойрт**вөл** харлана гэх мэт



a. –вал,

b. –вэл,

c. –вол,

d. –вөл.

Бүдүүвч № 8. Үйл үгийн нөхцөл бүтээврийн дөрвөл бүрэлдүүлбэр

Идэвхгүй “а-“ язгуур нь гээгдсэн “сан”, “даг” нөхцөлийг уг үгнээс нь саланги эгшиг зохицох дүрмийн ёсоор “**сан, сэн, сон, сөн; даг, дэг, дог, дөг**” гэж бичнэ. Жишээлбэл: явсан сан, явсан даг, ирсэн сэн, ирсэн дэг, очсон сон, очсон дог, өгсөн сөн, өгсөн дөг... гэх дүрэм бий. Энэ бол хэл зүйн үгийг илэрхийлсэн -сан 4, -даг 4 нөхцөл, түүний хувилбарууд юм.

Монгол хэлний харьцангуй бага нэгж авиалбар (а, à, ä, ^), бүтээвэр (-bar, -ber, -iyar, -iyer, -аар, -ээр, -оор, -өөр) дөрөв хүртэл хувилбар, бүрэлдүүлбэртэй байдаг явдал хэлний утгыг ялгаруулах, илэрхийлэх боломж юм. Үйл үгийн цагийг илэрхийлэх -juqui, -jüki, -çuqui, -çüki; -ba, -be, -bai, -bei; -на /-нэ, -но, -нө/; -лаа /-лээ, -лоо, -лөө/ дөрвөл бүрэлдүүлбэр нь үйлийн өнгөрсөн ба ирээдүй цагийн утгыг заана. Ш.Лувсанвандан: “Монгол хэлний үйлийн ерөнхий хамаатуулах нөхцөл нь ... дотроо:

- *мэдэгдэж өнгөрсөн цагт /-жээ, -чээ/*,
- *өнгөрөн үргэлжилсэн цагт /-лаа, -лоо, -лээ, -лөө/*,
- *мэдэгдээгүй өнгөрсөн цагт /-в, -б/*,
- *ирээдүй цагт /-на, -но, -нэ, -нө/* хамаатуулах нөхцөл гэж **ДӨРӨВ**

хуваагдана” (1968:75) хэмээн хэл зүйн утгад суурилж, үйл үгийн цагийн нөхцөлийн бичил тогтолцоог ажигласан байна. Мөн биед хамаатуулах –аарай /-ээрэй, -оорой, -өөрөй/; -аач/-ээч, -ооч, -өөч /; -аасай/-ээсэй, -оосой, -өөсөй/ гэх мэт хувилбар=бүрэлдүүлбэр **дөрвөл** юм. Эдгээр нь нийт хэлзүйн үйл үгийг дөрвөн хэсэг буюу *эгнээ* болгоно. Жишээ нь:



Бүдүүвч № 9. Хэлзүйн үгийн дөрвөл бүрэлдүүлбэр

Утга судлалын дөрвөл бүрэлдүүлбэр: Утгын харьцаа буюу шүтэлцээ нь: 1. Юм, 2. Ухагдахуун, 3. Хэлний тэмдэг, 4. Утга гэсэн дөрвөл бүрэлдүүлбэртэй ч юм. Ер хэл шинжлэлийн судалгаа нарийсах тутам хэл хэлэхүйн бүтэц, тогтолцооны хос, гурвал, дөрвөл бүрэлдүүлбэрийг нэмэн тодорхойлсоор байдаг ажээ. Хэлний нэгжийн утгын дөрвөл үүр буйг бид судалгаагаар нотолсон юм. Үгийн сангийн нэгж-үглэвэр нь:



1. Хүний толгой, 2. Өвсний толгой, 3. Цагаан толгой, 4. Том толгой. (Бадамдорж, Д. 2006:86)

Бүдүүвч № 10. Үглэврийн утгын үүр

Хэлний нэгжийн өөр хоорондын утгазүйн шүтэлцээнд **1. Ойролцоо утгат үг, 2. Эсрэг утгат үг, 3. Төсөө утгат үг, 4. Төрөл утгат үг** гэх дөрвөл бүрэлдүүлбэр нь хэлний ямарваа нэгж хоорондын утгын шүтэн барилдлагаар тодорхойлно.

Монгол хэлний үгийн санд зарим **төрөл утгат үг** /hyponymy, гипоними/ бол дөрвөл бүрэлдүүлбэрээр бүтсэн байдаг ажээ. Жишээ нь:

- Дөрвөн хаалга (...Сайн нь яснаас больюу, хурдан нь шөрмөснөөс больюу, хүч нь цуснаас больюу, зүрх нь цөвөөс больюу. Тэр нь хүчийг төрүүлэх дөрвөн хаалга буюу. (Лувсанбалдан. 1989:102) хэмээн танин мэджээ.

- Дөрвөн бэрх (дөрвөн шагай орхиход буусан морь, хонь, ямаа, тэмээ),
- дөрвөн хүчтэн (барс, заан, хангарьд, луу)

- Дөрвөн нохас, дөрвөн хүлэг (Монголын Нууц Товчоо зохиолын 209 дүгээр зүйлд: Чингис хаан: /Хувилай, Зэлмэ, Зэбэ, Сүбээдэй дөрвөн нохас, Боорч, Мухлай, Борохул, Чулуун дөрвөн хүлэг (Дашцэдэн. 1985:154) дөрвөл хүний хүчийг магтсан тухай өгүүлжээ.

Өгүүлбэрзүйн дөрвөл бүрэлдүүлбэр:

Монгол залгамал хэл нь үндсэн дараах дөрвөл бүрэлдүүлбэртэй юм. Тухайлбал, 1. Язгуур, 2. Дагавар, 3. Үг үндэс, 4. Нөхцөл болно. Язгуур дагавар хоёроос үг бүрэлдэнэ. Үг нөхцөл хоёроос өгүүлбэр бүрэлдэнэ. Энэ учраас үгийн сангийн үг, хэлзүйн үг гэсэн ялгаа гарах боловч, эл дөрвөл бүрэлдүүлбэр бол хүн харилцан нэвтрэлцэх өгүүлбэрт багтаж, цуваа бүтэц үүсгэж, санаа солилцох үргэлжийн хэрэглээтэй байна. Б.Рагчаа: “Монгол хэлний холбоо үгийг бүтцийн талаар нь:

“...**1. Үг+үг.** Жишээлбэл: сайн хүн, эр хүний бахдал, ах дүүгийн найрамдал... гэх мэт.

2. Холбоо үг+үг. Жишээлбэл: өргөн талд бэлч-, их хотын хөл үймээн ...гэх мэт.

3. Үг+холбоо үг. Жишээлбэл: уулын өндөр орой, сүхээр түлээ хагал- ... гэх мэт.

4. Холбоо үг+холбоо үг. Жишээлбэл: манай улсын эдийн засгийн хөгжил... гэх мэт.”

(Рагчаа. 1975:34) гэж холбоо үгийн дөрвөл бүрэлдүүлбэрийг тодорхойлсон байна. Мөн өгүүлбэрийг судлахад, М.Базаррагчаа: “**Хэл** нь тогтолцоонд, **хэлэх** нь үйл ажиллагаанд, **мэдэгдэхүүн** нь байгальд, **мэдэхүүн** нь нийгэмд тус тус тулгуурласан байдаг. Тэгвэл, өгүүлбэр нь байгаль, нийгмийн үзэгдлийг тусгаж, хүмүүсийн харилцааны хэрэглүүр болох бөгөөд өгүүлбэрзүй нь гүн ухаан ба логик, нийгэм ба сэтгэл судлалтай зүй ёсоор холбогддог ажээ.” (1985:04) хэмээн өгүүлбэрийг мэдэхүүн, мэдэгдэхүүн ба хэл, хэлэхийн дөрвөл талаас нь үзэх тухай бичжээ.

Эх судлалын дөрвөл бүрэлдүүлбэр: Б.Пүрэв-Очир: “Эх/текст/-ийн бүтэц, бүрэлдүүлбэр болон эхийн задаргааг тусгайлан судалсан зарим эрдэмтэн: ... Цогцолборуудыг бүрдүүлж байгаа өгүүлбэрүүдийнх нь шугаман хамаарал, гинжин холбооны байдлаар дөрвөн үндсэн хэв маягт хуваажээ. ... **Нэгдүгээр** хэв маяг буюу битүү цогцолбор, **Хоёрдугаар** хэв маяг буюу задгай цогцолбор, **Гуравдугаар** хэв маяг буюу битүү цуварсан гинжин холбоо бүхий

цогцолбор, *Дөрөвдүгээр* хэв маяг буюу задгай цуварсан гинжин холбоо бүхий цогцолбор...” (2002:19-20) хэмээн эхийн нэгж болсон цогцолборын хэв маягийн бүрэлдүүлбэрийг тодорхойлсон байна. Эхсудлалд эл дөрвөл бүрэлдүүлбэр бол онол, дадлагын ач холбогдолтой ажээ.

Түүхэн хэлзүйн дөрвөл бүрэлдүүлбэр: Монгол хэлний түүхийг нарийвчлан судалсан монгол хэл шинжээчид манай хэлний хэрэглэгдэхүүнд тулгуурлаж, монгол хэлний хөгжлийг дөрвөн үе шаттай хөгжиж ирсэн гэж үзжээ. Энэ бол монгол хэл хөгжлийн дөрвөл бүрэлдүүлбэр бүхий гэсэн үг юм.

Д.Төмөртоогоо: “0.121. Өвөг монгол хэл,
0.122. Эртний монгол хэл,
0.123. Дундад үеийн монгол хэл,
0.124. Орчин үеийн монгол хэл” (1992:3-9)

гэж үечилсэн байгаа нь үе болгон онцлогтой учир түүхэн хөгжлийн дөрвөл бүрэлдүүлбэр болно.

Найруулга зүйн дөрвөл бүрэлдүүлбэр: Монгол хэлний тухайн судлагдахууныг ангилахад дөрвөл бүрэлдүүлбэртэй болох нь аяндаа мэдэгдэнэ. М.Базаррагчаа: “...Тухайн нэг сэдвийг хэд хэдэн хувилбараар, тухайлбал, тоочих ба эргэцүүлэх, хүүрнэх ба тайлбарлах хэв маягаар ялгаруулан бичиж болно. Өөрөөр хэлбэл, найруулбар нь **дөрвөн** хэв маягтай юм. Энэ дөрөв нь хүүрнэх ба тоочих, батлах ба үгүйсгэх, захирах ба хүсэх, асуух ба таамаглах өгүүлбэрийн голлох шинжийг агуулсан байдаг. ...**Тоочимж** нь үйл ба хэрэг явдлын зогсонги шинжийг тодорхойлох тул орон зайн холбогдолтой бол, **хүүрнэмж** нь хэрэг ба үйл явдлын хөдлөнг шинжийг дүрслэх тул цаг хугацааны холбогдолтой байдаг. Тэгвэл, **эргэцүүлэмж** нь ухагдахуун хоорондох харьцаанд тулгуурласан бодомж, оюун дүгнэлт байдаг бол **тайлбарламж** нь төсөөлөлд тулгуурласан ухаалаг санааг агуулсан байдаг” (2003:45-46) гэж дөрвөл бүрэлдүүлбэрийг дурджээ.

Аялгуу судлалын дөрвөл бүрэлдүүлбэр: Хэлний судлагдахууны өвөрмөц онцлог шинжийг танин мэдээд, түүндээ үндэслэж, оновчтой ангилал хийсний үр дүнд хувьсал хөгжлийн бүрэлдүүлбэрийг олж тогтоодог ажээ. Тухайлбал: Ш. Лувсанвандан олон монгол хэл аялгууг сурвалжлан судалж, **дөрвөн** үндсэн аялгуу буюу монгол аялгууны тархцыг тодорхойлсон байна. Үүнд:

Нэг. Төв аялгуу...

Хоёр. Дорнод аялгуу...

Гурав. Өрнөд аялгуу...

Дөрөв. Умард аялгуу...(1959:27) Эл ангилал бол орчин үеийн нийт хэл аялгуу нь дөрвөл бүрэлдүүлбэртэй болохыг тогтоосон хэрэг юм.

Хүн төрөлхтний хэлний ямарваа үзэгдэл бол хэрэглээний явцад ижил төстэй шинжээрээ аяндаа бие биедээ амьсан нэгдэж, цэгцрэн эрэмбэлэгдэж, бичил бүтэц, тогтолцоо үүсдэг байна. Хэл шинжээчид тэрхүү аяндаа цэгцрэн бүрэлдсэн бичил бүтэц, тогтолцоог танин мэдээд, төрөл бүрийн **ангилал** хийсэн байдаг ажээ. Ангилал бүр өөртөө бүрэлдүүлбэртэй байх зүй тогтолтой юм. Бидний ажиглаж буй дөрвөл бүрэлдүүлбэртэй бичил тогтолцоо бол монгол хэлний нэгэн өвөрмөц цэгцэрсэн тогтоц, ихэвчлэн, өвөг тогтвортой хэв шинж [prototypes (stereotypes)] юм.

ХОЁР. Монголчуудын сэтгэлгээний дөрвөл бүрэлдүүлбэр

Монголчууд **дөрвөөр** хэмжээлэн сэтгэн бодож, танин мэдсэн *хур мэдлэг* уламжилсан бөгөөд тэр нь бүхэл буюу ерөнхий зүйлийн чанар, хэсэг буюу тусгай зүйлийн шинжийг илэрхийлсэн байдаг ажээ. Монгол соёл иргэншилд оюуны соёлын зүйл хийгээд амьдралын хэрэглээний дархлаа тогтсон ч гэж болох юм. Тухайлбал: Монголын утга зохиолын хэлнээ буй дөрвөл бүрэлдүүлбэртэй нэгж цөөнгүй. Жишээ нь:

Дөрвөн бэрх (Халуун, хүйтэн хошуутай малыг төлөөлсөн эсрэгцэлт, хос бэлгэдэлт дөрвөл бүрэлдүүлбэр: Морь, хонь, тэмээ, ямаа)

Дөрвөн мөрт (дөрвөн мөртэй шүлэг), *Гайхалтай*

“Хар малгайтай залуу эхнэрийн
Үзэсгэлэнг би ихэд магтана
Халзан толгойтой түүний нөхрийн
Аргыг би бас сайшаана.”

(Д.Нацагдорж. 1930 он) гэх мэт.

Энэчлэн монголчууд дөрвөөр хэмжиж нэрийдсэн дөрвөл бүрэлдүүлбэртэй, зүйлчилсэн сэтгэмж бий. Тухайлбал:

ДӨРВӨН УЛИРАЛ: Хавар, зун, намар, өвөл;

ЖИЛИЙН 4 УЛИРАЛ

ДӨРВӨН ЗҮГ: Өмнө, баруун, хойно, зүүн;

ДӨРВӨН АРГЫН ТОО: Нэмэх, хасах, үржих, хуваах;

ДӨРВӨН МӨЧ: Баруун гар, зүүн гар, баруун хөл, зүүн хөл;



Бүдүүвч № 11. Дөрвөл бүрэлдүүлбэр.

Ийнхүү дөрвөл бүрэлдүүлбэрт сэтгэлгээний бичил тогтолцоо буй нь мэдэгдэж байна.

Дүгнэлт

Монголын утга зохиолын хэлний тогтолцоонд дөрвөл бүрэлдүүлбэрт өвөрмөц бичил тогтолцоо нь цуваа цагт аяндаа цэгцрэн бүрэлдэж, хэлний нэгжийн утгыг илэрхийлэх, зөв бичих, зөв дуудах зэрэгт үндэслэл болсон байна. Хэлний зарим нэгж нь онцлогдох нэг төрлийн өнгөн бүтэц, гүн бүтэц бүхий дөрөв дөрвөөрөө амьсан нэгдэж, бичил тогтолцоо үүсгэсэн ажээ. Тухайлбал:

Нэг. Монгол хэлний үглэврийн хүчлэг өргөлтөт эгшигтэй балархай **дөрвөл** эгшиг зохицож, утгыг хамжин хавсарч илэрхийлдэг ажээ. Жишээ нь: Дармал, нэхмэл, **ормол**, **гөрмөл** гэх мэт.

Хоёр. Зарим дөрвөл бүрэлдүүлбэрт нэгж нь эгшиг зохицох ёсоор **зөв дуудах** боломжийг бүрэлдүүлдэг байна. Жишээ нь: Мандуулъя, оролцъё, дэвшүүлъя, ерөөе /я, ё, е, е/ гэх мэт.

Гурав. Дөрвөл бүрэлдүүлбэрт бүтээврийн хувилбарыг **зөв бичих** дүрэм буй. Жишээ нь: Эгшигт гийгүүлэгчээр төгссөн үйл үгийн үндэст -л нөхцөлийн хувилбарыг зөв бичсэнийг ажиглана уу. Малла-, дэвтэрлэ-, номло-, өвлө- гэх мэт

Дөрөв. Монгол хэлний хэл зүйн үг, үгийн сангийн үг баяжихад, дөрвөл бүрэлдүүлбэрт нэгж бол гол үүрэг гүйцэтгэдэг ажээ. Жишээ нь: **Би, миний, намайг, надад** (хэл зүйн үг); **Хол, хул, хөл, хүл-** (үгийн сангийн үг) /уруулын о, у, ө, ү дөрвөн эгшиг эсрэгцэж утга ялгана./ гэх мэт.

Ном зүй

Монгол хэлээр

- Бадамдорж, Д. 2006. Монгол хэлний үгийн сангийн утгазүй. Уб. 86.
- Бадамдорж, Д. 2021. Монгол хэлний бүрэлдүүлбэр судлал. Уб. 09, 17.
- Базаррагчаа, М. 1985. Өгүүлбэрийг мэдэхүүн, мэдэгдэхүүн ба хэл хэлэхийн талаас үзэх нь. Уб. 04.
- Базаррагчаа, М. 2003. Монгол хэлний сүгээр ба найруулбарын тухай. Уб. 45-46.
- Базаррагчаа, М. 2005. Эртний монгол хэлний үгийн бүтэц, түүний зарим онцлог. Уб. 244.
- Дамдинсүрэн, Ц. 1957. Монгол хэл бичгийн тухай. Уб. 145, 152.
- Дамдинсүрэн, Ц. Осор, Б. Монгол үсгийн дүрмийн толь. Редактор С. Мөөмөө. Уб. 411.
- Дашцэдэн, Т. 1985. Монголын нууц товчоо. Галиг. Уб. 154.
- Лувсанбалдан, Х. 1989. Хүлгийн шинж. Улсын хэвлэлийн газар. Уб. 102.
- Лувсанвандан, Ш. 1939. Mongyol kelen-ü jüi. Ulaanbaatur. 30, 40, 62-63.
- Лувсанвандан, Ш. 1959. Монгол хэл аялгууны учир. Уб. 27.
- Лувсанвандан, Ш. 1967. Орчин цагийн монгол хэлний зүй. Монгол хэлний авианы бүтэц. Тэргүүн дэвтэр. Уб. 54, 64, 87.
- Лувсанвандан, Ш. 1968. Орчин цагийн монгол хэлний бүтэц. Монгол хэлний үг нөхцөл хоёр нь. Уб. 75, 105, 108, 109, 163.
- МХШДБ.1983. Монгол хэлний шинжлэлийн дурсгал бичиг. ӨМАХХ. Хөх хот. 11.
- Надмид, Ж. 1967. Монгол хэл, түүний бичгийн түүхэн хөгжлийн товч тойм. Уб. 74.
- Напил, Б. 2021. Монгол хэл зохиол судлалын хөгжил, чиг хандлага. ОУЭШХ-ын Эмхэтгэл. Уб. 102.
- ОЦМХ. 1966. Орчин цагийн монгол хэл зүй. Ерөнхий редактор академич Ш. Лувсанвандан. УБ. 56, 68, 230-231.
- Өнөрбаян, Ц. 2000. Орчин цагийн монгол хэлний үйл үг бүтэх ёс. Уб. 100.
- Пагва, Т. 1957. “Зүрхний тольтын тайлбар”-ыг судалсан тухай тэмдэглэл. Уб. 30.
- Пүрэв-Очир, Б. 2002. Монгол хэлний эхзадлалын асуудлууд. 4. Уб. 19-20.
- Рагчаа, Б. 1975. Орчин цагийн монгол хэлний бодит нэрийн холбоо үг. Уб. 34.
- Ринчен, Б. 1966. Монгол бичгийн хэлний хэлний зүй. Дэд дэвтэр. Авиан зүй. УБ. 316, 398-399.
- Самбуудорж, О. 2022. Монгол хэлний бага хос авиалбарын тухай. Хэл зохиол судлал. Боть XV (47) 129-134.
- Санжаа, Ж. Надмид, Ж. 2008. Монгол хэлний авиазүй ба авиалбарзүй. Уб. 117.
- Төмөртоогоо, Д. 1992. Монгол хэлний түүхэн хэлзүй. Уб. 3, 3-9, 174.
- Төмөрцэрэн, Ж. 2001. Монгол хэлний үгийн сангийн судлал. Уб. 19.
- Урьхан, Х. 2022. Өвөг монгол хэлний үгийн эхний хоёр уруулын хамжих *р гийгүүлэгчийн түүхэн хувьсал. Хэл зохиол судлал. Боть XV (47) 166.
- Чойжинжав. 1989. Монгол хэлний зүйн судлал. ӨМИС-ийн хэвлэх үйлдвэр. Хөх хот. 280-281.

Орос хэлээр

- Бобровников, А. 1849. Грамматика монгольско-калмыцкого языка. Казань. 97.
- Владимирцов, Б. Я. 1929. Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия. Введение и фонетика. Ленинград. 118, 311.
- Галсан, С. 1975. Сопоставительная грамматика русского и монгольского языков. (фонетика и морфология) Часть 1. Улан-Батор. 30.
- Кобозева, И.М. 2019. Лингвистическая семантика. Москва. 84-98.
- Маслов, Ю.С. 2005. Введение в языкознание 4-е издание, стереотипное. Москва, С.-Петербург. 157.

- Санжеев, 1960. Современный монгольский язык. Москва. 79.
- Тодаева, Б. Х. 1951. Грамматика современного монгольского языка. Фонетика и морфология. Ленинград. 13, 124-127.
- Тодаева, Б. Х. 1864. Баоаньский язык. Москва. Стр. 05
- Шмидт, Я. 1832. Грамматика монгольского языка. Санктпетербургъ. Стр. 25
- Англи хэлээр*
- Solntsev, V.M. 1983. Language: a System and a Structure. Nauka publishing house. Moscow. 65.
- Tserepil, D., Kullmann, R. 2005. Mongolian grammar. UB. Printed in Mongolia. 113.
- Geoffrey Leech. 1974. Semantics. Penguin Books. Greet Britain. 235.
- John Lyons. 1995. Linguistic semantics. An introduction. Cambridge University press. 108.

Abstract

In this article, the author found that four component is in Mongolian language system. The author notes that there is the four component in linguistics subsystems such as Mongolian linguistics: phonetics, phonology, graphemes, lexicology, syntax, morphology, stylistics and semantics.

It is said that this is basic concept for research and studies. For example, Short vowels: **o, u, ö, ü**; compound vowels: **ō, ū, õ, ũ**; diphthongs: **öē, ũē, ôē, ũē**; **-Tan /-ton, -ten, -tön/** means that this suffix varies in compliance with vowels harmony with the following four vowels: a, o, e, ö “-tan /-ton, -ten, -tön/” etc.

Keywords: Mongolian language, four component, structure, meaning